

АЖ ТӨРӨХ  
УХААН

Г.Ловор

# СОННИН ЮУТАЙ ВЭ?



II  
ангийнханд  
зориулав

**Г.Ловор  
Сонин юутай вэ?**

*Бага сургуулийн 2-р ангийн сурагчдад зориулав.*

Зураач	Л.Зулбадрах
Хянан тохиолдуулагч	Д.Сугархүү
Хянагч	О.Мөнхтуяа
Хэвлэлийн эх бэлтгэсэн	Ж.Гэрэлмаа
	Н.Хөдөлмөр
	Д.Хишигдэлгэр



Хэвлэн нийтлэлийг Интерпрес ХХК

2007 он

# СОНИН ЮУТАЙ ВЭ?

Хүн төрөлхтний бусад амьтдаас ялгарагч нэг онцгой чанар нь ухаалаг, сониуч зантай нь билээ. Сониуч зан гэдэг нь мэдээ, мэдээлэл сонсож, мэдлэгээ баяжуулж шийдэлд хүрэх арга зам юм.



Хүн төрөлхтөн бүр балар эрт цагт бие биедээ дохио зангаа, дуу чимээ гаргаж мэдээ хүргэдэг байж. Дуу авиа нь хөгжсөөр хэл яриа болж, хэл яриа хүрэхээргүй алс газар бол овог отгийнхондоо мод чулуу балбаж бөмбөрдөх юм уу, очиж сонсгохыг хичзэнэ.

Дараа нь морь, мал эдэлж сурснаас хойш түүнийг унаж мэдээ хүргэдэг болж. 13-р зууны үед Монголчууд, мориор өртөөлөн мэдээ хүргэдэг байв. Энэ нь шуудангийн үүтгэл болжээ.



XIX зуун хүн төрөлхтний түүхэнд үг мэдээ дамжуулахад хувьсгал хийв. Соронзон аппарат бүтээж алс газар мэдээг цахилгаанаар дамжуулдаг болжээ.

Бас телефон утсаар харилцдаг, төдөлгүй радио долгиноор үг яриа дамжуулж, нэвтрүүлдэг болов.

Хожим дүрсийн мэдээ хүргэдэг зурагт радио, зурагт-телефон бий болов.



Одоо компьютер нэвтэрч интернетийн сүлжээгээр дэлхий дахинь аль ч улс орны хүмүүстэй гэр орондоо сууж байгаад харилцах өргөн бололцоотой боллоо.

Гэвч хүн төрөлхтний сониуч зан үүгээр бүрэн ханахгүй нь мэдээж. Бие биетэйгээ уулзах хүн болгон “Сонин юутай байна даа?” гэдэг асуулт тавьсаар байх болно.



Ялангуяа бэлчээр, усны ая дагаж нүүдэллэж, таруу нутагладаг малчид бол уулзсан хэнтэй ч болов энэ асуултыг мэнд мэдсэнийхээ дараа тавьдаг.

Арга ч үгүй юм. Алс суудаг аав зэж, ах дүү, анд нөхдийнхөө ажил төрөл, ахуй амьдралын тухай захиа бичгээр төдийхэн бус амаар сонсохыг хүсэлгүй яахав.

Малчид ХХI зуунд гэрээсээ (Кибер гэр) дуртай газар уруугаа утсаар, цаад хүнээ харж байгаад ярьдаг, нарны зайгаар дуртай сувгаараа зурагт үздэг, "утаагүй улаан гал"-д тогоогоо залгаж хоол цайгаа болгон, тавлаг суудаг болно. Малаа ч хариулдаг, хардаг роботтой болохыг хэн байг гэхэв. Тийм хүсэл эрмэлзэл байсан цагт ч "Сонин юутай байна даа?" гэсэн асуулт тавьсаар байх болно.

## **Бага сургуулийн 2-р ангийнханд зориулав.**




Монголчуудын хот хүрээ гэдэг ойлголт юунаас үүссэн бэ?



Хот сууринд суугчдын өдөр тутмын мөрдөх нэг чухал хууль бол замын хөдөлгөөний дүрэм.



Малчдын ажиллах, амьдрах нөхцөлөөс ургаж гарсан таатай сууц.



Монголчуудын амьдралын гол хэрэглээ идээ шүүс, хоол ундаа цаг хугацаа, ёс горимтой зооглодог тухай.



Хүн төрөлхтөн өдөр тутмын мэдээлэл сонирхон олж авдгийн ачаар амьдрал ахуйгаа хөгжүүлэн зохицуулж, ирээдүйгээ төсөөлдөг.



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Хөдөвгийн боловсролыг дэмжих (READ) төсөл"-ийн хүрээнд хэвлэв.  
Худалдахыг хориглоно.